



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/235

Ховд

Мал эмнэлэг, ариун цэвэр,
Халдваргүйжүүлэлтийн ажил зохион
байгуулах тухай

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны А/52 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/08 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлэг, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг бүх нийтийг хамарсан ажил болгон 2019 онд мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл нэг сарын аян зохион байгуулж, хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэм устгах, хашаа саравч өтөг бууц ариутгах ажилтай орон нутгийн ажлыг уялдуулан ажлын хэсэг байгуулан ажиллуулж, түүнд шаардагдах халдваргүйжүүлэлтийн бодис бусад зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг сум, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Мал эмнэлэг, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажлын нэгдсэн удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, халдваргүйжүүлэлтийн ажил явуулсан дүн мэдээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Мал эмнэлэг, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн сарын ажлыг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулж, сум орон нутгийн Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүдийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд шаардагдах халдваргүйжүүлэлтийн бодис, бэлдмэлээр хангах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

 Т.ЖАРГАЛСАЙХАН

02.01162
D/Zax-A/235-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
04 дүгээр сарын 15-ны өдрийн
А/235 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

УДИРДАМЖ

Мал эмнэлэг, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажлын тухай

Энэхүү удирдамжийн зорилго нь: Хүн, мал, амьтны халдварт өвчин гарахаас сэргийлж зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх, бэлчээр, усны эх булаг, өвөлжөө, хаваржааны өтөг бууц хашаа хороо, мах, түүхий эдийн захын байр агуулах, талбайг халдваргүйжүүлэн цэвэрлэх мал эмнэлэг ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажлыг сумын хэмжээнд эрчимтэй зохион байгуулахад оршино.

Нэг.Хийгдэх ажил.

Сум, багийн түвшинд.

а.Сум, багийн Засаг даргын захирамж гарган, Мал эмнэлэг ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн сарын ажлыг зохион байгуулах.

б.Уг ажилд шаардагдах хүн хүч, унаа тээврийн хэрэгслийн болон бусад зардлыг шийдвэрлэж, орон нутгийн байгууллага, эмч мэргэжилтэн, малчдыг өргөнөөр татан оролцуулах.

в.Мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэхэд олон нийтийн үүсгэл санаачлагыг өрнүүлэн энэ ажлын зорилго, ач холбогдол, ололт дутагдлыг өргөн сурталчлах.

2.Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн түвшинд зохион байгуулах ажил.

а.Ариутгал халдваргүйжүүлэлт хийх мэргэжлийн хүмүүсийг усны гутал, хамгаалалтын шил, ус үл нэвтрэх материалаар хийгдсэн хувцас, резинен болон берзентен бээлий, нүдний шил зэрэг хөдөлмөр хамгааллын хувцасаар хангагдсан байна.

б.Мал, амьтны хүүр, сэг зэмийг өвөлжөө, хаваржаа, хашаа хорооноос цааш зайд 500-800 метр зайд, автомашин, үерийн замаас зайдуу газарт 1.5-2 метр гүн нүхэнд 1 малын сэг зэмд 30-50 гр хлорын шохой оногдохоор бодож ариутгалын бодис хийж булах буюу шатааж устгана.

в.Мал, амьтны хашаа хороо өтөг бууцыг сэндийлж овоолон биотермийн аргаар халдваргүйжүүлнэ.

г. Мал, амьтны хүүр, сэг зэм байсан газар, тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг хог тоосноос цэвэрлэж 25 хувийн идэвхт хлор агуулсан хлорын шохойн 2 хувийн уусмал болон ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисоор зааврын дагуу халдваргүйжүүлэх.

д. Булаг шандны эхийг цэвэрлэж, тойруулан хаших, малын ялгадас, бороо цасны ус орохоос хамгаалсан суваг шуудуу татах арга хэмжээ авахуулах.

е. Цэвэрлэгээ ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

ё. Мал амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгааллын шаардлагыг бүрэн хангуулах.

ж. Ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн ажлын явц, хэрэгжилтэнд мэргэжлийн хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах.

Малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд хийгдэх ажлууд.

а. Мэргэжлийн байгууллагын заавар, удирдамжийн дагуу ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн ажилд идэвхтэй оролцох.


б. Мал, амьтны хашаа, хороог цэвэрлэж, бууцаа сэндийлж хөрзөнг гадагш гаргах, хураах, шатааж устгах ажлыг гүйцэтгэж, халдваргүйжүүлэлт хийхэд бэлэн болгох.

в. Өвөлжөө, хаваржааны ойр орчимд байгаа мал, амьтны сэг зэмийг цуглуулан устгах, булах, уст цэг, булаг шандны эхийг цэвэрлэх, хамгаалах ажлыг хамтран гүйцэтгэх.

Хоёр. Ажлыг дүгнэх, мэдээлэх.

1. Сарын ажлын үр дүнг сумаас аймгийн Мал эмнэлгийн газарт 7 хоног тутам мэдээлж, нэгдсэн тайланг сумаас мал эмнэлгийн үйлчилгээний нэгж бүрээр гарган сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж мэдээг Мал эмнэлгийн газарт 5 дугаар сарын 20-ны дотор гаргаж ирүүлэх.

2. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан ажлын үр дүнг 05 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөл, Онцгой комиссын хурлаар хэлэлцэж дүгнэлтийг Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлнэ.



Аймгийн Засаг даргын 2019 оны
04 дүгээр сарын 15-ны өдрийн
А/235 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН
20... ОНЫ.....-Р САРЫН МЭДЭЭ

Сумын нэр	Хариуцсан МЭҮН-ийн нэр		Түүхий эд, бүтээгдэхүүнхадгалах цэг, зoorь, тэжээлийн агуулах		Малын хашаа, хороо, мал амьтны тоног хэрэгсэл		Худаг, уст цэг		Халдваргүйжүүлсэн бүс, цэг		Балчарийн талбай M ²	Нийт M ²	Ариутгал, халдваргүйжүүлэлтэд хэрэглэсэн эмийн			
	Тоо хэмжээ, ширхэг	Талбай, M ²	Тоо хэмжээ, ширхэг	Талбай, M ²	Тоо хэмжээ, ширхэг	Талбай, M ²	Тоо хэмжээ, ширхэг	Талбай, M ²	Тоо хэмжээ, ширхэг	Талбай, M ²			Нэр	Зарцуулсан хэмжээ /л/	Гаргасан нийт зардал /мян.төг/	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13			

Мэдээ нэгтгэсэн эмч...../...../ (Гарын үсэг) (Нэр)

Хянаж зөвшөөрсөн: Тасгийн дарга...../...../ (Гарын үсэг) (Нэр)

ТЭМДЭГ

20... оны ... сарын ... өдөр